



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/М

Мандалговь

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний
агентлагуудын 2016 оны үйл ажиллагааны
үр дүнгийн тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, 40.5 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2011 оны А/474 дугаар захирамжаар баталсан "Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын 6.3, 6.5 дахь заалт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2017 оны 02 сарын 02-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авч Тэргүүн байр эзэлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг "Өргөмжлөл" 700000 /Долоон зуун мянган/ төгрөг, хоёрдугаар байр эзэлсэн Мэргэжлийн хяналтын газрыг "Өргөмжлөл" 500000 /Таван зуун мянган/ төгрөг, гуравдугаар байр эзэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг "Өргөмжлөл" 200000 /Хоёр зуун мянган/ төгрөгөөр тус тус шагнасугай.

Гурав. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авч ажилласан хэлтэс, агентлагийн дарга нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн сандаа багтаан олгохыг холбогдох агентлагийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Шагналд зарцуулагдах 1550000 төгрөгийг /Нэг сая таван зуун тавин мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

Тав. Хяналт шинжилгээ үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллахыг агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

Зургаа. "Дутагдалтай" үнэлгээтэй дүгнэгдсэн Татварын хэлтэст зөвлөн туслах ажлыг зохион байгуулахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



020000035

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дугаар сарын 02 ны өдрийн А/Н тоот захирамжийн хавсралт

Агентлагуудын 2016 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн ХШҮ-ний дүнгийн нэгтгэл

2017.01.30

№	Агентлагын нэр	Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээ		Үнэлгээний дундаж хувь	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ			Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ		Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ	Үнэлгээний дундаж хувь							
		Аймгийн засаг даргын 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн агентлагт холбогдолтой заалтын биелэлт	Эрх зүйн актын хэрэгжилт		Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шүүд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт	Байгууллага, албан хаагчдын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ		Байгууллагын шударга байдлын үнэлгээ	Засгалын болон нөхцөл зүйн засгийн хөтөлбөрийн үзүүлэлтийн үнэлгээ	Хэрэглэсний үнэлгээ	Үнэлгээний дундаж хувь	Ерөнхий хувь	Дундаж оноо	Үнэлгээ	
1	ЭМНДХ		98	98.00	94.45	91.38	95	93.61	95	83.2	89.10		85.6	85.60	91.58	4.58	Санаачлагатай сайн	
2	МХГазар	100	96.6	98.30	100	100	70	90.00	100	90	95.00		98	98.00	95.33	4.77	Санаачлагатай сайн	
3	СХАА	100	50	75.00	90	100	90	93.30	90	100	95.00	90	88	89.00	88.08	4.40	Хэвийн	
4	ҮЦУОЦА	88.4	82	85.7	85.36	95	98	97.26	96.75	88	88.7	88.35		96.6	96.50	91.77	4.69	Санаачлагатай сайн
5	БОАЖГ	88	90	94	90.60	91.12	97.9	99.5	96.10	92	100	96.00	100	98	99.00	95.43	4.77	Санаачлагатай сайн
6	ОБГазар	90	90		90.00	90	100	70	86.70	90	90	90.00		94	94.00	90.18	4.51	Санаачлагатай сайн
7	ГБХЗХГ	94	92.25	88	91.40	91.7	95.6	100	95.70	90.2	86.4	88.30		83.2	83.20	89.65	4.48	Хэвийн
8	СХЭХ	90	82	84.6	85.53	90	91.8	92.5	91.43	83	90	86.50		91	91.00	88.62	4.43	Хэвийн
9	ЭМГ	92.8	100	92	95.00	94.76	87	100	93.90	94	98	96.00	82	81.6	81.80	91.68	4.58	Санаачлагатай сайн
10	СХалтас	91	91.6		90.80	92.4	87.63	81.6	87.21	83.6	84	83.80		95.2	95.20	89.25	4.46	Хэвийн
11	ТХалтас	87.5	83		85.25	86.6	87.5	65	73.03	74.4	74.4	74.40		77.2	77.20	77.47	3.87	Дутгалтай
12	ГБХХБГ	94	92.4	92	92.80	91.4	93.5	100	94.96	89.25	93.4	91.30		92.33	92.33	92.85	4.64	Санаачлагатай сайн
13	УБХ	100	98.6		99.30	91.4	90	90	90.46	83.12	85	84.06		91.6	91.60	91.36	4.57	Санаачлагатай сайн
14	ХХҮГазар	95.65	90	90	91.86	91.5	95.6	93.5	93.53	95.9	90	92.95	88.4	82	85.20	90.89	4.64	Санаачлагатай сайн
15	ХХЛАГ	82	82	84	86.00	84.06	91.7	97.1	91.00	89.1	86.5	87.80	95.2	76.6	85.90	87.68	4.38	Хэвийн
16	БТСГ	70	95	83.75	83.00	84.43	92.4	85.5	87.40	78.8	90	84.40		70	70.00	81.20	4.06	Хэвийн
17	БСУГ	98	100	97.4	98.47	93	96	100	96.30	88	97.3	92.80	86	60	73.00	90.10	4.51	Санаачлагатай сайн
18	ШШГА	100	96.9		98.40	92.9	90	95	92.60	86.2	90	88.10		96.6	96.60	93.93	4.70	Санаачлагатай сайн
19	ШША	70	90		80.00		80	95	87.50	75		75.00		80	80.00	80.63	4.03	Хэвийн
20	ЦГазар	90	90	89.3	89.70	91.9	88	92.5	90.80	86	93.6	89.80	99.5	80.8	90.10	90.10	4.51	Санаачлагатай сайн
	Дундаж оноо	91.12	89.82	89.18	90.24	91.40	91.70	90.47	91.11	87.58	90.03	88.43	91.59	85.92	97.77	89.39	4.47	